



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

МЭДЭЭ

180 /180/

2021.11.15

ТУСГАЙ ДУГААР

АРТИЛЛЕРИЙН ЦЭРЭГ ҮҮСЭЖ ХӨГЖСӨНИЙ 100 ЖИЛИЙН ОЙН МЭНДИЙГ ДЭВШҮҮЛЬЕ!



Артиллерийн цэргийн 100 жилийн ойн баярын хурал энэ өдөр офицеруудын ордонд зохион байгуулагдаж байна.

Баярын хуралд ЭХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг, БХЯ-ны ТЗУГ-ын дарга, хурандаа С.Ванчинхүү, ЭХЖШ-ын БСТГ-ын дарга, бригадын генерал Ц.Гандорж, Зэвсэгт хүчний ХЗЦ-ийн штабын дарга, бригадын генерал Л.Онцгойбаяр, Монголын Артиллерийн цэргийн холбооны тэргүүн, бэлтгэл хошууч генерал Б.Баярмагнай нарын хүндэт зочид төлөөлөгчид оролцож байна.

Артиллерийн цэргийн 100 жилийн ойн хүрээнд “Артиллерийн цэргийн түүхэн замнал, өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулсан билээ. Тус эрдэм шинжилгээний бага хурлын үндсэн илтгэлийг тоймлон хүргэж байна.

АРТИЛЛЕРИЙН ЦЭРГИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Түүх нь хэзээ, хаана, хэн, юу бүтээв, ямар сургамж үлдээв гэдэгт хариу өгдөг, өнгөрсөн-одоо-ирээдүй гэсэн гурван цагийн хэлхээ холбоог илэрхийлдэг үнэт зүйл билээ. Артиллер нь олон шинжлэх ухаантай холбогдох цогц ойлголт бөгөөд түүнийг судалж эзэмшсэн хүнийг Артиллерчин гэнэ.

Артиллерчид нь эзэмшиж буй зэвсэг, техникийг инженерийн ухаанаар судлан

ашиглах, буудлага, гал удирдахдаа математикийн шинжлэх ухаан, физик, хими болон агаар мандлын хөгжил хөдөлгөөн, газар зүй, геодезийн шинжлэх ухаанд тулгуурлан мэргэжлийн нэгтгэл, анги салбарыг операци, байлдаанд ашиглахдаа цэргийн шинжлэх ухааныг удирдлага болгон хөгждөг.

Орчин цагийн Артиллерийн цэргийн

түүхэн хөгжлийн замналыг авч үзэхдээ МАХЦ-ийн Артиллерийн цэрэг (1921-1932), эх орныхоо тусгаар тогтнолыг хамгаалах тэмцлийн үеийн артиллерийн цэрэг (1932-1945), МАХЦ-ийг цомхотгон зохион байгуулах үеийн артиллерийн цэрэг (1946-1955), МАА-ийн артиллерийн цэрэг (1956-1989), Артиллерийн цэргийн хөгжлийн шинэ үе (1990-2021).



МАХЦ-ИЙГ ЦОМХОТГОН ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЕИЙН АРТИЛЛЕРИЙН ЦЭРЭГ (1946-1955)

Дэлхийн II дайны дараа БНМАУ-ын Засгийн газраас ахмад насны цэргийг чөлөөлөх, анги, нэгтгэлүүдийг цомхотгон батлан хамгаалах зардлыг хорогдуулах ажил явагдсан. МАХЦ-ийн хэмжээнд мотомеханикжсан 1 бригадтай болж их бууны

анги, салбарууд цөөрсөн учир Улсыг Батлан Хамгаалах Яамны сайдын 1953 оны 6 дугаар сарын 1-ний өдрийн 0113 тоот тушаалаар их бууны газрыг татан буулгаж байлдааны бэлтгэл хэлтэст тасаг болгон өөрчилсөн.

Дайны дараах 10 жилд МАХЦ-ийн хийсэн

цомхотгол нь тухайн цаг үедээ зайлшгүй байсан боловч артиллерийн анги, салбаруудын байлдааны бэлн байдал, боловсон хүчний бэлтгэлд тасралт бий болгосон.

Энэ үед артиллерийн анги, салбарууд улс ардын аж ахуйд шаардлагатай



МАХЦ-ИЙН АРТИЛЛЕРИЙН ЦЭРЭГ НЬ (1921-1932 ОН)



1921 оны 3 дугаар сарын 5-10-нд жанжин Д.Сүхбаатарын санаачлага, шууд удирдлагаар Оросын 1902 оны 76 мм-ийн 2 буутай анхны их бууны салаа байгуулагдсан нь орчин цагийн артиллерийн цэргийн анхны суурь тавигдсан.

Энэ үе бол Монгол Улсын Зэвсэгт хүчинд их бууны шинэ төрөл үүсэн

бий болж орчин цагийн их буучид төрөн гарч, их бууны шинжлэх ухааныг судлах, хөгжүүлэх их ажлын эхлэл байв.

Их бууны буудлага, тактикийн ажиллагааг зааварчилсан дүрэм, журам зэргийг 1926 оноос гарган мөрдсөн нь их буучдын сургалтанд ихээхэн ач холбогдолтой болж,

Монголчууд түүхэндээ анх удаа далд харааны буудлага хийж эхэлсэн.

Цэргийн мэргэжилтнүүд, түүний дотор их буучдыг гадаад оронд /анх удаа/ бэлтгэх болсон нь Епропын соёл Монголд нэвтэрч цэргийн дарга нарын боловсрол, мэргэжлийг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой байлаа

ЭХ ОРНОХОО ТУСГААР ТОГТНОЛЫГ ХАМГААЛАХ ТЭМЦЛИЙН ҮЕИЙН АРТИЛЛЕРИЙН ЦЭРЭГ (1932-1945)



Манай орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд аюул заналхийлж байсан жилүүдэд их буучдын мэргэжлийн ур чадвар өсч далд харааны буудлагыг дүүрэн бэлтгэлийн үндэстэй чадварлаг хийдэг болсны дээр 1000 метр хүртэлх зайд хөдөлгөөнтэй ба хөдөлгөөнгүй цельд чиг шагайлтын буудлагыг хийдэг болсон.

МАХЦ-ийн их бууны зэвсэглэл шинэчлэгдэж бүтэц зохион байгуулалт нь боловсронгуй болсоор тухайн үеийн шаардлагын хэмжээнд хүрсэн байв.

1939 оны Халх голын байлдааны өөрийн болон дайсны цэргийн их буучдын тактик, буудлагын арга барилыг харьцуулан судлаж дүн шинжилгээ хийж байсны дээр дэлхийн II дайны үеийн

байлдааны туршлагыг цаг алдалгүй судалж байсан нь манай их буучдын тактикийн сэтгэлгээг хөгжүүлж, буудлагын арга барил, ур чадварыг дээшлүүлэхэд ач холбогдлоо өгсөн юм.

Их буучдын дотроос БНМАУ-ын баатар 4 /В.Шарав, Л.Гэлэгбаатар, Данзанваанчиг, Б.Цог/ төрж олон арван хүн төрийн дээд шагнал хүртсэн.

МАА-ИЙН АРТИЛЛЕРИЙН ЦЭРЭГ (1956-1989)



хэмнэсэн шинэ санаа, санаачилгуудыг дэмжиж байлаа.

Артиллерийн хэлтсийг 1979 онд "Газар" болгон өөрчилсөн. Мөн онд нисдэг тэрэгний тусламжтай хийх тогтоол буудлагыг анх удаа "Таван толгойн" буудлагын талбайд 120 дугаар ангийн тагнуулын дивизионы захирагч Ц.Лувсанням удирдаж "онц" үнэлэлттэй хийсэн бөгөөд 1980 онд хяналтын цэгийг таван толгойн "Их улаан хад"-ны оройд авч дахин буудлага хийсэн нь амжилттай болсон.

1965, 1967, 1975, 1979 онд одоогийн бидний ашиглаж байгаа артиллерийн зэвсэглэл, техник, тагнуулын болон тооцооны багаж хэрэгсэл Зөвлөлтөөс тусламжаар орж ирсэн.

Ингэж их бууны анги, салбарууд 1965-1979 оны хооронд артиллерийн зэвсэглэл, техник 7 дахин нэмэгдэж шинээр 8 төрлийн буу, 6 төрлийн багаж хэрэгсэлээр хангагдаж түүнийг шинээр эзэмшсэн.

1986 онд Артиллерийн газрын даргын нэршлийг өөрчилж зарим орон тоог хассан бол 1988 онд Артиллерийн газрыг хэлтэс болгон өөрчилж 6 хүний орон тоотой болгожээ. Энэ үед ном сурах бичиг нилээд гарсан тухайлбал Артиллерийн бэлтгэлийн курс I, II дэвтэр, Артиллерийн дивизион байлдаанд, Артиллерийн буудлага, гал удирдах дэвтэр гэх мэт.

Артиллерчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх нэг хөшүүрэг нь мэргэжлийн зэрэгтэн, хос мэргэжилтэн болох хөдөлгөөнийг өрнүүлсэн. Үүний үр дүнд 1980-1989 оны хооронд мастер 25, I зэрэг 291, II зэрэг 1095, III зэрэг 6628 бүгд 7923 хүн зэрэгтэй болсон. Артиллерийн мэргэжлийн мастерийн зэргийг 1984 онд АА-ийн 8 дугаар ТЭСАХ-ны салааны захирагч дэслэгч П.Оюунбат танк эсэргүүцэх бууны операторчны мэргэжлээр эзэмшсэн бол түүнээс хойш Г.Мөнхөө, Ш.Эрдэнэбаяр, Ж.Ванчинсүрэн, Р.Канад, Г.Сүхбаатар нарын 30 гаруй офицер артиллерийн тооцоочны мастерын зэрэг эзэмшжээ.

Артиллерчид нисдэг тэрэг, РЛС, авиа зүйн иж зэрэг

тухайн үеийн шинэ тагнуулын техник хэрэгслийг эзэмшиж бүх системээр төрөл бүрийн буудлагыг төрөл бүрийн аргаар хийж чаддаг болсны дээр дүүрэн бэлтгэлийг артиллерийн буудлагын үндсэн арга болгож чадсан.

Артиллерийн мэргэжлийн боловсон хүчний боловсролын түвшин жилээс жилд өндөржиж ялангуяа академийн боловсролтой офицерын эзлэх хувь 1973 оноос хойш 2,5 дахин нэмэгдсэн.

1974 онд "Офицер бүр шинэ зүйлийг санаж ажилдаа нэвтрүүл" үүргийн дагуу хэлтсээс 120 мм-ийн Миномётоор буудах хялбарчилсан уулын буудлагын таблиц, дүүрэн бэлтгэлийн тооцоог богино хугацаанд бодох тооцоолгч,

далдуур удирдлагын ярианы таблиц, ахмад Н.Доржхандын "Дивизионы даргын хайрцаг", хошууч Агваанжамбын "засвар бодох багаж", хошууч Л.Долгоржавын "хээрийн хайрцаг", дэд хурандаа Б.Арслангийн "цахилгаанжсан ил харааны буудлагын дадлагын талбай" зэрэг шинэ санаачлага тэргүүн туршлага гарсан.

Артиллерчдын мэргэжлийн бэлтгэлийн үсрэнгүй өсөлт 1970-1989 бөгөөд энэ хугацаанд артиллерийн командлал буудлага, гал удирдах бэлтгэлийг дээшлүүлэхэд чиглэсэн олон чухал арга хэмжээг авч байсан. Үүний үр дүнд салаа, салбарын офицеруудын мэргэжлийн ур чадварын өсөлт эрс нэмэгдсэн байлаа.

БНМАУ-ын хөрш хоёр гүрэн харилцан сөргөлдөх болсон нь тус улсын үндэсний эрх ашигт сөргөөр нөлөөлж төр засгийн удирдлага олон улсын цэрэг улс төрийн байдалд дүгнэлт хийж зарим цэргийн анги, салбаруудыг шинээр байгуулж эхэлсэн.

1964 онд Их бууны хэлтсийг шинээр байгуулж ЗХУ-аас мэргэжилтэнүүд олноор ирсэн төдийгүй шинэ төрлийн зэвсэглэл, цэргийн техник ихээр орж ирсэн.

1967 онд АА-ийн сургуулийн төвийг татан буулгаж АА-ийн танк эсэргүүцэн сөнөөх артиллерийн тусгай дивизион болгон өөрчилж Улиастайд зохион байгуулжээ /одоогийн 120 дугаар анги/.

1967 оны 8 дугаар сард шинэ зэвсэглэл, техник олноор хүлээн авсаны нэг нь БМ-14, ТЭЗП 9П122 байлаа. Шинэ зэвсэглэл техникийг хүлээн авахын зэрэгцээ 1968

онд "Газрын артиллерийн буудлагын дүрэм", "Газрын артиллерийн гал удирдах заавар" зэрэг ном сурах бичиг, 1973 оноос уулын буудлагын таблицыг ашиглаж эхэлсэн нь их буучдын цэргийн хэргийн мэдлэгийн өсөлтөнд ач холбогдолоо өгсөн.

Их буучдын тактик тусгай бэлтгэл, анги, салбарын жигдрэлтийг хангахаар Армийн артиллерийн командлалаас 1975 онд буудлага, тактикийн аварга батарей, тактик-тусгай бэлтгэлийн тэргүүний салаа, батарейны дарга шалгаруулах тэмцээнийг сөөлжүүлэн жил бүр явуулдаг болсон.

"Ардын Арми" сэтгүүлд "Артиллерийн буудлагын уралдаан" зарлаж, их буучдын туршлага солилцох зөвөлгөөн, заавал нэвтрүүлэх тэргүүн туршлагын жагсаалт-аргачлал гаргаж нийтийн хүртээл болгох, артиллерийн галын нарийвчлал, бүтэмжийг дээшлүүлэх, цаг хөдөлмөр

ГАДААДЫН УЛС ОРНУУДЫН АРТИЛЛЕРИЙН ХӨГЖИЛ



Артиллерийн зэвсэглэл, техник, багаж хэрэгслийн байлдааны боломжыг нэмэгдүүлэхэд лазер, оптик ба мэдээллийн цоо шинэ ололтыг ашиглаж тэдгээрийн тооцоолох системийг оюунжуулсаны үндсэн дээр тагнах, удирдах, устгах хэрэгслийг нэгтгэсэн нэн цэцтэй зэвсгийн систем нэвтрүүлж, артиллерийн галт хэрэглэлийн шинэ төрлийг бүтээх замаар галын хүчин чадлыг дээшлүүлж цоо шинэ ололтыг нэвтрүүлж байна.

2000 оноос ихэнх улс орнууд зэвсгийн удирдлагыг автоматжуулах, түүнд ОХУ болон АНУ-д үйлдвэрлэсэн

олон зориулалтын дан болон хос гол төмөрт дугуйт, гинжит өөрөө явагч артиллер, миномёт, олон зориулалтын тийрэлтэт артиллерийн автомат системүүдийг худалдан авах эсвэл сайжруулан зэвсэглэлдээ нэвтрүүлж эхэлсэн.

2010 оноос дэлхийн хөгжингүй улс орнууд уян хатан солигддог гол төмөртэй, олон зориулалтын сум /минэ/ хэрэглэдэг, хөнгөн, өндөр маневртай, удирдлагатай, хагас удирдлагатай хуягт системүүд /105, 122, 152, 155 мм-ийн ОЯГ, 60, 82, 120 мм-ийн ОЯМ/-ийг эрчимтэй хөгжүүлж зэвсэглэлдээ оруулж байна.

Дэлхийн хөгжингүй улс орнууд артиллерийн зэвсэглэлийг дараах чиглэлээр хөгжүүлэхэд анхаарч байна. Үүнд:

- Цэрэг, техникийн удирдлагыг автоматжуулах;
- Тагнуул-галын, тагнуул-цохилтын цогцолбор;
- Өндөр маневртай цэргийн бүлэглэлтэй тэмцэх ухаалаг хэрэгсэл;
- Нэн өндөр цэцтэй зэвсэг;
- Өндөр бүтээмж, боломжит техник;
- Нисгэгчгүй нисэх аппаратыг нэвтрүүлэх;
- Төрөл бүрийн роботыг цэргийн хэрэгт нэвтрүүлэх.

МОНГОЛ АРДЫН АРМИЙН АРТИЛЛЕР /50 –80 ОН/



ДҮГНЭЛТ



Дэлхийн артиллерийн хөгжлийн чиг хандлага, хуулиар хүлээлгэсэн үүргүүдэд зохицуулан артиллерийн анги, салбаруудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, артиллерийн хүний нөөц бэлтгэх тогтолцоог улам боловсронгуй болгох, мэргэжлийн бэлтгэлийг шинэ түвшинд гаргаж артиллерчдын ур

чадварыг нэмэгдүүлэх, одоо ашиглагдаж байгаа артиллерийн зэвсэглэл, техникийн ашиглалтын болон хөдөлгөөнт чанарыг сайжруулах, артиллерийн системүүд, тагнуулын багаж хэрэгслийн автоматчлагдах түүнтэй холбох асуудлыг шийдвэрлэх, орчин үеийн зэвсэглэл, техник, галт хэрэгслийг зэвсэглэлдээ нэвтрүүлэх.

Өөрийн орны судлаачдын орлуулсан, сайжруулсан багаж хэрэгсэл, зэвсэглэл, техникийг нэн яаралтай байлдааны туршилтанд оруулж дүгнэлт гаргуулан олноор үйлдвэрлэх хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж өгөх, тэднийг урамшуулах нь зүйтэй байна. Улаан залаат их буучдад шинэ зууны амжилт хүсэн ерөөе!

Улаан залаат их буучдад шинэ зууны амжилт хүсэн ерөөе
ЗХЖШ-ын БСТГ-ын СТХ-ийн Артиллерийн ахлах мэргэжилтэн,
хурандаа Д.МӨНХСАЙХАН